



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**

Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж 2,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976-51) 26 36 95, Факс: (976-11) 32 35 41
Цахим шуудан: letter@moh.gov.mn
Цахим хуудас: www.moh.gov.mn

2024 06 19 № 22694
танай _____-ны № _____-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА БОЛОН ЗООНОЗЫН ӨВЧИН
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ,
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЗАХИРАЛ НАРТ

Хамтран ажиллах тухай

Тарваган тахал өвчний улиралчлал эхэлж байгаатай уялдуулан уг өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах Эрүүл мэндийн сайдын 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн “Тарваган тахал өвчний хяналт, сэргийлэлтийн арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 01 дүгээр албан даалгаврыг үүгээр хүргүүлж байна.

Нутаг дэвсгэрийнхээ хүрээнд энэхүү албан даалгаврын хэрэгжилтийг хангаж, хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт: 5 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



Д.ОЧИРБАТ

144243675



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Тарваган тахал өвчний хяналт,
сэргийлэлтийн арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Монгол Улсын 17 аймгийн 137 сумын 443.300км² нутаг дэвсгэрт тарваган тахлын нутагшмал голомттой. Зоонозын өвчин судлалын үндэсний төвөөс гаргасан тарваган тахлын байгалийн голомтын аюулын зэрэглэлээр 15 аймгийн 81 суманд хүний өвчлөл гарах эрсдэл өндөр байна.

ЗӨСҮТ болон 14 салбар ЗӨСТ-үүд нь 2023 онд тарваган тахлын байгалийн голомтын хяналт шинжилгээний төлөвлөгөөт ажлын хүрээнд улсын хэмжээнд голомтот аймгийн 94.1% (15), сумдын 32.8% (45)-ийг хяналт, шинжилгээнд хамруулсан байна. Шинжилгээнд нийт 1.820.763 га талбайг хамруулж, 2192 мэрэгч туулай хэлбэртэн, 464 зэм үхдэл, 1746 махчин шувуудын гулигдас, 4908 гадны шимэгчийг цуглуулан шинжилж, 3 аймгийн 8 сумын нутагт хамрагдах байгалийн голомтоос тарваган тахлын өсгөвөр 36, эерэг сорьц 37 тус тус илрүүлсэн байна.

Монгол Улсын хэмжээнд судалгаанд хамрагдсан бүс нутгийн тарваган тахал өвчний үндсэн болон дэд агуулагчийн нягтшил мэрэгч бүрт үзвэл: Монгол тарвага 1 га-д дунджаар 1.93, урт сүүлт зурам 1 га-д 2.3, огдой 1 га-д 1.8, үлийн цагаан огтоно 9.3 тус тус ноогдож байна. Мэрэгчийн 1 га дах нягтшилийг өмнөх онтой харьцуулахад тарвага хэвийн бөгөөд харин зурам, огдой, үлийн цагаан оготоны дундаж нягтшил 1.1- 2%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Тарваган тахлыг дамжуулагч болох бүүрэгний хувьд: Олзворлосон нийт мэрэгчийн үс ноолуурт бүүрэгний ноогдоц дунджаар—2.9, тохиолдоц 46.1%, нүхний амсарт ноогдоц—0.13, тохиолдоц—2.01%, ноохойн ноогдоц—12.9, тохиолдоц-100%-тай байна. Тарваган тахал өвчнийг дамжуулагч бүүрэгний ерөнхий нөөц дунджаар тарвага 7.6, урт сүүлт зурам 16.1, чичүүлд 6.9, үлийн цагаан оготно 14.5 ноогдож байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 0.3-6.6%-иар өссөн ба ялангуяа зурамны бүүрэгний ерөнхий нөөц 6.6%-иар өссөн нь хэрэв халдвар гарвал дамжуулах чадамж өндөр байна.

Үндсэн агуулагч Монгол тарваганы нягтшил нь газар нутаг бүр харилцан адилгүй алаг цоог тархалттай бөгөөд Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай аймгуудын шинжилгээ хийсэн зарим сумдад тоо толгой нь өсөх хандлагатай ба дунджаар 1га-д 1.8-6.6 ноогдож байна. Жижиг мэрэгчийн нягтшилийн хувьд: Урт сүүлт зурам болон огдой нь өмнөх оноос эрс буурсан ба харин үлийн цагаан

143240005

оготоны хувьд өмнөх жилд Төв, Завхан, Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт 1 га-д дунджаар 7.1-31.7 нягтшилтай байсан бол энэ жил Төв, Дундговь, Өвөрхангай аймгуудын нутагт 1 га-д 20.3-29.6 болж ихэссэн байна.

2023 онд тарваган тахлын өсгөвөрийн 77.7% нь тарваганы үхдэл, зэмээс, 16.6% нь олзворлосон тарваганы эд эрхтнээс, 5.5% нь тарваганы бүүрэгнээс тус тус илэрсэн байна. Шинжилгээний дүнд Монгол Алтай дэрлэгүүн голомтод хамаарах Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай зэрэг 3 аймгийн 8 сумын 14 бичил голомтоос тарваган тахлын нян 36 илэрч, 120600 га талбай эпизоот идэвхтэй байгааг тогтоож өмнөх оноос 36.400 га талбайгаар тэлсэн байна.

Түүнчлэн Монгол Улсын дотоодын аялал жуулчлалын төв зам нь тарваган тахлын нутагшмал голомттой бүс нутгаар дайран өнгөрдөг нь тухайн нутгийн оршин суугчдаас гадна гадаад, дотоодын жуулчид халдварт өртөх эрсдэл өндөр байна. Мөн иргэд тарвагыг хууль бусаар агнах, худалдаалах, хүнсэнд хэрэглэх, хот суурин газар руу тээвэрлэх байдал тасралтгүй гарсаар байна.

Монгол оронд 2012-2023 онд тарваган тахлын нийт 22 тохиолдол, 9 нас баралт (CFR40.9%) бүртгэгдсэн байна.

2023 онд Говь-Алтай, Завхан, Ховд аймаг, Улаанбаатар хотод тарваган тахлын хүний өвчлөлийн 5 тохиолдол гарч, 1 хүн нас барсан. Олзворлосон мэрэгч амьтдаас тарваган тахлын үүсгэгч *Y.pestis ssp.pestis* илрүүлсэн зэрэг нь нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсэх нөхцөл, бүрдээд байна.

Тарваган тахлын хүний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудын нэг нь хүн амыг дархлаажуулалтад хамруулах юм. Жил бүр тарваган тахлын улиралчлалыг угтуулан голомттой бүс нутгуудад тарваган тахлын эсрэг дархлаажуулалтыг зохион байгуулдаг. 2022 онд 21795 хүнийг дархлаажуулалтад хамруулсан, 2023 онд улиралчлалыг угтуулан дархлаажуулалт хийгдээгүй. 2023 оны 11 дүгээр сард Оросын Холбооны улсын Ставрополийн тарваган тахлын хүрээлэнгээс 1 туншилдаа 156 хүн тунгаар савлагдсан нийт 56160 хүн тун тарваган тахлын эсрэг амьд, хуурай вакцин хүлээн авсан.

Иймд тарваган тахал өвчний хяналт, сэргийлэлтийн арга хэмжээг эрчимжүүлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажиллах чиглэлээр дараах арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг үүрэг болгож байна. Үүнд:

Нэг. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

- 1.1 Тарваган тахал болон бусад зоонозын халдварт өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах;
- 1.2 Тарваган тахал өвчний сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед ажиллах салбар хоорондын багийг томилж сургаж дадлагажуулах;
- 1.3 Тарваган тахлын байгалийн голомтын тандалт судалгаа, дархлаажуулалт урьдчилан сэргийлэлт, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ

үзүүлэх эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлэх;

- 1.4 Хууль бус ан агнуур, тарвага, тарваганы гаралтай түүхий эдийн худалдаа, тээвэрлэлтэд хяналт тавих мэргэжлийн байгууллагуудыг үүрэгжүүлэх;
- 1.5 Тарваган тахлын сэжигтэй тохиолдлын голомтыг хязгаарлах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах;
- 1.6 Нийгмийн сүлжээнд хууль бусаар тарвага агнах, худалдаалахтай холбоотой мэдээллийг хянаж, таслан зогсоох;
- 1.7 Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоон дахь хяналтыг сайжруулах;
- 1.8 Тарваган тахлын байгалийн голомт өндөр идэвхтэй байгаа аймаг, сумдын голомтын эрсдэлийг бууруулахад мэрэгчгүйтгэл, шимэгчгүйтгэлийн ажлын санхүүжилтийг шийдэх

Хоёр. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төв, төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад:

- 2.1 Эрүүл мэндийн сайдын 2017 оны 160 дугаар тушаалаар батлагдсан "Тарваган тахал өвчний хариу арга хэмжээний заавар"-ыг хэрэгжүүлэн ажиллах;
- 2.2 Хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөцийг бүрдүүлэх, нөхөн хангалт хийх;
- 2.3 Тарваган тахлын голомтод бусад салбар хоорондын байгууллагын үйл ажиллагааг уялдан зохицуулах, мэргэжил арга зүйгээр хангах;
- 2.4 Эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг хангуулах, тухай чиглэлээр дэмжлэгт хяналт хийх;
- 2.5 Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, мэдээлэл, сурталчилгааны ажил зохион байгуулах;
- 2.6 Тарваган тахал өвчний байгалийн голомтын болон хүн амын дундах тандалт судалгааг зохион байгуулж, үр дүнд суурилсан арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;
- 2.7 Тарваган тахлын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед яаралтай дуудлагын багийн гишүүдийн бэлэн байдлыг хангах, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцтэй дуудлагад явуулж хэвших;
- 2.8 Тарваган тахал өвчний улиралчлал эхэлсэнтэй холбогдуулан эрүүл мэндийн ажилтнуудыг сонор сэрэмжтэй байж болзошгүй, сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлэх тархвар судлалын холбогдлыг тогтоох асуумж авах, ялган оношилгооны талаар сургалтад хамруулах;
- 2.9 Эмнэлзүйн төстэй шинж тэмдэг илэрсэн тохиолдол бүрээс тархвар судлалын асуумж, судалгааг нарийвчлан авах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах;
- 2.10 Тарваган тахлын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед 2 цагийн дотор

- ЗӨСҮТ-д яаралтай мэдээлж, эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн зэрэгт тохирсон голомтын хариу арга хэмжээ авах;
- 2.11 Тархвар судлалын холбогдол бүхий эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өөрийгөө яаралтай тусгаарлах, харьяа эрүүл мэндийн байгууллагад зөвхөн утсаар дуудлага өгөх талаар иргэд, олон нийтэд мэдээлэл өгөх;
 - 2.12 Шалтгаан тодорхойгүй халуурсан тохиолдол бүртгэгдсэн үед тархвар судлалын асуумж авч, эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэн тусламж, үйлчилгээ үзүүлэх;
 - 2.13 Тарваган тахлын дархлаажуулалтыг 2024 оны 06 дугаар сарын 20-оос 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор орон нутагт зохион байгуулах, вакцин тарих, найруулах, аюулгүй байдлыг ханган ажиллах талаар цахим сургалтад холбогдох эмч, вакциаторуудыг хамруулах, эрсдэлт бүлгийн хүн амыг хамруулах, хамралтын мэдээг 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЗӨСҮТ-д ирүүлэх;
 - 2.14 Албан даалгаврын хэрэгжилтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ЗӨСҮТ-д ирүүлэх

Гурав. Зоонозын өвчин судлалын үндэсний төвд:

- 3.1 Бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэх;
- 3.2 Тарваган тахал өвчний байгалийн голомтын тандалт судалгааг хийж, үр дүнг тухай бүр нь мэдээлэх;
- 3.3 Тарваган тахал өвчний оношилгоо, тандалт судалгаанд шаардлагатай оношлуур, урвалж, хамгаалах хувцас хэрэгсэл тоног төхөөрөмж, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөцийн бэлэн байдлыг хангах;
- 3.4 Тарваган тахлын сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн үед тархвар зүйн тандалт судалгаа, лабораторийн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийх мэргэжлийн багийг томилж, тохиолдлын удирдлагын тогтолцооны горимд шилжин ажиллах;
- 3.5 Тарваган тахал өвчний батлагдсан тохиолдлын голомтод ажиллах, дэгдэлт гарсан тохиолдолд газар дээр нь мэргэжлийн баг томилон ажиллуулах, голомтыг цомхотгон дарах;
- 3.6 Тарваган тахал өвчнөөс сэргийлэх мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлэх, ялангуяа хууль бусаар тарвага агнасан үед авах хариуцлагын арга хэмжээг сурталчлах;
- 3.7 Тарваган тахал өвчнөөс сэргийлэх, оношлох, эмнэлзүй, ялган оношилгоо, лабораторийн шинжилгээ, эмчилгээний талаар эрүүл мэндийн байгууллагуудад цахим сургалт хийх, мэргэжил арга зүйгээр хангах;
- 3.8 Тарваган тахлын дархлаажуулалтыг орон даяар зохион байгуулах, вакцин тарих, найруулах, аюулгүй байдлыг ханган ажиллах талаар цахим сургалт

хийх, мэргэжил аргазүйгээр ханган эрсдэлт бүлгийн хүн амыг хамруулах,
тайланг нэгтгэн мэдээлэх

Дөрөв. Тайлагналт:

4.1 Албан даалгаврын хэрэгжилтийг улсын хэмжээнд нэгтгэн 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийтийн эрүүл мэндийн газарт ирүүлэхийг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Б.Амгаланбаяр)-д даалгасугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ